



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/118

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 03, 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдол түүний хавьтлыг бүртгэх, тандалтын процессыг автоматжуулах зорилгоор "Гэрэгэ Системс" ХХК-наас нэвтрүүлж буй "ЭрүүлМН" платформыг хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Г.Чанцалням ("Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК
-ны Дундговь аймгийн газрын
ашиглалтын менежер)

Гишүүд:

- А.Сайханбилэг (Онцгой байдлын газрын Холбоо
зарлан мэдээлэл хариуцсан
мэргэжилтэн)
- Э.Лхагвасүрэн (Цагдаагийн газрын холбооны
инженер)
- Н.Мөнгөн (Засаг даргын Тамгын газрын
Мэдээлэл технологийн ажилтан)
- Ч.Мөнхжаргал (Эрүүл мэндийн газрын
Мэдээллийн технологи хариуцсан
мэргэжилтэн)

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдол, түүний хавьтлыг бүртгэх, тандалтын процессыг автоматжуулах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Чанцалням)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210322